



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 5/42

Хэрлэн сум

**Буцалтгүй тусламж олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, аймгийн Засаг даргын Тамгын газрын “Дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер Лувсандоржийн Цэнддоржийн гаргасан өргөдлийн дагуу магистрын сургалтын төлбөрт 2900000 (хоёр сая есөн зуун мянган) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжид шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын тэтгэмж, урамшууллын зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод ажил, агентлаг хариуцсан мэргэжилтэн (Ш.Эрдэнэжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР